

## НОГООН ЭДИЙН ЗАСГИЙН ЧИГ ХАНДЛАГА, МОНГОЛ УЛС ДАХЬ ХЭРЭГЖИЛТ

*Ц.Даваахүү\**

***Abstract:** This study reveals green economy and green developments in Mongolia, otherwise comparing the developing and developed countries green economy. This work is mainly focused on analysis and compare of international development of green economy and development of Mongolia. Last decades, whole the world is trying to reach from brown economy to green economy rapidly, due to developing countries mainly responsible for this section also, Mongolia is the first countries of in Asia to developing green economy which is the advantage of other countries. Furthermore, Green economy determined by office, procurement, building and people daily usage at all.*

*Result of study can imply, Mongolians green economy development rapidly raised but, scientific research of green development, financing improvement are most important to improve green economy ways.*

***Key words:** Mongolia, Green Economy, Green Development, Sustainable development*

\* \* \*

XXI зууны томоохон тулгамдаж буй асуудлууд болох байгалийн нөөц баялаг, уур амьсгалын өөрчлөлтийн хурдац нэмэгдэж, байгалийн олон янз байдал алдагдаж, ус, хөрсний бохирдол ихсэж, байгалийн гамшгийн тоо хэмжээ түүний давтамж өссөөр байгаа нь ирээдүйд бидэнд учирч болох аюул занал, хойч ирээдүйнхээ төлөө амьдралын хэв маяг, уламжлалт хөгжлийн шинэчлэлийг боловсруулах шаардлага өдгөө ногоон эдийн засгийн хэрэгцээ, шаардлага бий болж байна.

Иймд, дэлхийн хэмжээнд тогтвортой хөгжлийн бодлого, ногоон хөгжлийг хэрэгжүүлэхийн хүрээнд хэд хэдэн удаагийн давтамжтайгаар баримт бичиг, дээд хэмжээний уулзалт зэргүүдийг зохион байгуулсны үндсэн дээр “Ногоон хөгжил” хэмээх ойлголтыг салбар, нэгж болгонд тусгаж ирээдүйн хойч, байгаль экологи, эдийн засгийн тулгамдаж буй асуулуудыг нийтэд нь тусган шийдвэрлэх арга замыг хайж байгаа билээ. Үүний үндсэн үндсэн дээр Ногоон хөгжлийн бодлогын тодорхойлолтыг хэд хэдэн янзаар тайлбарласан байна.

2012 онд Бразил Рио де жанейро хотноо хуралдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын /НҮБ/ чуулганаас “Бидний хүсч буй ирээдүй” баримт бичгийг баталж, тогтвортой хөгжилд хүрэх, ядуурлыг бууруулах арга зам бол ногоон эдийн засаг юм хэмээн тусгасан байна.<sup>218</sup>

НҮБ-ийн байгаль орчны хөтөлбөр нь “Хүний сайн сайхан, нийгмийн тэгш, хүртээмжтэй байдлыг сайжруулахын зэрэгцээ байгаль орчны эрсдэл, экологийн

\* БОХТ, Аялал жуулчлал Газрын Харилцааны сургууль, Монголын Үндэсний Их Сургууль

<sup>218</sup> Нэргүй, 2015

доройтлыг эрс бууруулж чадаж буй эдийн засгийг ногоон эдийн засаг гэнэ. Ногоон эдийн засгийн хамгийн энгийн тодорхойлолт нь хүлэмжийн хийн ялгарал багатай, нөөцийг үр ашигтай зарцуулдаг, нийгмийн тэгш, хүртээмжтэй байдлыг хангах гэж тодорхойлсон байна.<sup>219</sup>

Дэлхий ертөнцийг нийтэд нь хамруулан авч үзэн, байгаль, эдийн засаг болон нийгмийн олон янз байдлыг цогц байдлаар хамтад авч үзэх нь ногоон хөгжил юм .

2015 оны 9-сарын 25-27-ны өдрүүдэд хуралдсан НҮБ-ийн Ерөнхий Ассемблейн 70-р чуулганаар Тогтвортой хөгжлийн 17 зорилтыг баталсан<sup>220</sup> бөгөөд үүнтэй уялдуулан Монгол улсын Ногоон хөгжлийн бодлого түүний төлөвлөгөө, хэрэгжилт мөн Монгол улсын Тогтвортой хөгжлийн бодлого, үндэсний хөтөлбөр зэргийг батлан үйл ажиллагаа явуулан эхэлж байна.

Монгол улсын ногоон хөгжлийн бодлогыг 2014 оны 6-р сарын 13-ны өдөр 43-р тогтоолоор баталж, Ногоон хөгжлийн үзэл санаанд тулгуурласан, иргэдийн оролцоог хангасан эдийн засгийн өсөлтийг бий болгосноор хүрээлэн байга орчны тогтвортой байдлыг хадгалан ирээдүй хойч үедээ өвлүүлж, үр өгөөжийг нь урт хугацаанд хүртэх боломжоор хангах нөхцөлийг бүрдүүлсэн хөгжингүй улс болно<sup>221</sup> хэмээн зорилгыг тавин 6 зорилтыг дэвшүүлэн 2030 он хүртэл төлөвлөгөө боловсруулагдсан байна.

Монгол улсын Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд, ногоон эдийн засгийн бодлогын дүн шинжилгээ, ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлт, ногоон ажлын байр, сургуулийн ногоон барилга байгууламж, ногоон үйлдвэрлэл, хэрэглээ, тогтвортой худалдан авалт, хог хаягдлын менежмент, ногоон хөгжлийн боловсролын чиглэлээр<sup>222</sup> дагнан хэрэгжүүлэх хэмжээнд явагдаж байна.

Дээрх хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд явагдаж буй **ногоон худалдан авалт, эко парк, ногоон эдийн засагт халтай барилга, байгууламж, ногоон ажлын байр, хөшүүргийн систем зэргийн** олон улсын туршлагын харьцуулалт тэдгээрийн нэгтгэл болон түүнд дүгнэж анализ хийн, өнөөгийн Монгол улсын чиг хандлага ирээдүйн төлөв байдлыг судлахад оршино<sup>223</sup>.

## Судалгааны үр дүн

**А. Ногоон худалдан авалт.** Тогтвортой худалдан авалт нь амьдарлын шаардлага дээр тулгуурласан, хариуцлага болон тогтвортой хөгжлийн менежментийн зарчимтай, өрсөлдөөнт зах зээлийг хянах зэрэг бодлого зарчмууд дээр тулгуурласан байна<sup>224</sup>.

<sup>219</sup> United Nations Environment Program, 2010

<sup>220</sup> Нэргүй, 2015

<sup>221</sup> Ногоон хөгжил, түүнийг хэрэгжүүлэх үндэсний тэргүүлэх чиглэл, 2016

<sup>222</sup> Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл, 2016

<sup>223</sup> Frone Simona et.al, 2015

<sup>224</sup> What is the green economy, 2009

НҮББОХ, БОНХАЖЯ, Сангийн яам хамтран “Тогтвортой худалдан авах ажиллагаа” төслийг 2015 оны 2-р сард хэрэгжүүлж эхэлсэн<sup>225</sup> бөгөөд хуулийн дахин шинэчлэл, боловсруулалт нь 2016 онд батлагдсан болно.

Ногоон худалдан авалтын хүрээнд, зөвхөн өөрийн хэрэгцээг хангахаас гадна байгаль орчинд сөрөг, эерэг нөлөөлөл зэргийг тооцон худалдан авалт хийх нь ногоон хөгжлийн үзэл санаа баримтлалыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болно. Үүнээс гадна байгаль орчинд ээлтэй ногоон үйлдвэрлэл, бүтээгдэхүүн үйлчилгээнд эко шошго зэргийн батламж олгон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дэлхийн бренд компаниудыг дурьдаж болно. Эдгээрт, Nike 2013 онд гутлын үйлдвэрлэлд тогтвортой хөгжлийн зарчмыг баримтлан, бүх талаас ээлтэй байх индекс боловсруулсан инноваци бий болгосон. Coca Cola нь усны хэрэглээг 20%-иар хэмнэж чадсан мөн Dell компани нь бүтээгдэхүүнээ үйлдвэрлэхдээ эрчим хүч хэмнэх зорилгоор дахин боловсруулсан түүхий эд ашигласан бөгөөд 2020 онд гэхэд эрчим хүчний хэрэглээгээ 80% хүртэл бууруулахаар ажиллаж байна.<sup>226</sup>

Түүнчлэн, тогтвортой худалдан авалт хэмээх ойлголт нь нийгмийн хүрээнд дэх мэдлэг, ойлголтын хувьд харьцангуй бага бөгөөд хувь хэвшлийн болон улсын байгууллагуудын тусламжтайгаар явагдаж үй ажиллагаа юм. Монгол улсын хэмжээнд эхний ээлжинд тэргүүлэх бараа бүтээгдэхүүнийг судлан, эрэмбэлэх, түүн дээр үндэслэн ногоон оффисын олон улсын стандартын зэргийг судалж харьцуулах явдал юм. Энэхүү эрэлттэй бараа бүтээгдэхүүний хэрэгцээн дээр үндэслэн А4 цаасны судалгааг эмхтгэн, эдийн тооцоо зэргийг судалсан бөгөөд цаасны түүхий эд болох мод нь өөрөө байгалийн шавхагддаг нөөц баялагт орох үнэ цэнэтэй байгалийн биет юм.<sup>227</sup>

Мод нь өөрөө маш олон төрлийн үйлчилгээний эх үүсвэр болох ба үүний дотор, уламжлалт аж үйлдвэр болох мод үйлдвэрлэл, цаасны түүхий эд мөн, аялал жуулчлал, эрчим хүч болон усны менежментийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг нэгжийн нэг юм<sup>228</sup>. Тиймдээ ч, энэхүү тогтвортой худалдан авалтын хамгийн энгийн жишээ болох цаасны эрэлт хэрэгцээ, түүхий эд зэрэг нь асуудал дагуулж байгаа билээ. Доорх тоон мэдээ баримтаар:

1 мод ургахдаа 500 л усыг хангадаг ба 189 л усыг цаас үйлдвэрлэхэд зарцуулдаг. 1 тн цаас үйлдвэрлэхэд ойролцоогоор 17 мод шаардагдах бөгөөд оффисийн хэрэглээний цагаан цаасыг үйлдвэрлэхэд 24 мод шаардагдана. 12 мод нь сонингийн цаас үйлдвэрлэхэд шаардагдах ба 25м<sup>3</sup> ус, 10,061 кв эрчим хүч тус тус шаардагдана (9).

цаасны үнэ цэнэ өөрөө ямар өндөр болохыг харуулж байхаас гадна дэлхийн улсуудын нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний дүнгээс өндөр

<sup>225</sup> Тогтвортой худалдан авах ажиллагаа, 2016

<sup>226</sup> Нэргүй, 2015

<sup>227</sup> Даваахүү, 2016

<sup>228</sup> Forests in a green economy, 2013

хөгжилтэй орнуудын цаасны хэрэглээ бусад улс орнуудыг бодвол ойролцоогоор 10 дахин их хэрэглээтэй байна.

Мөн одоогоор Монгол улсад мөрдөгдөж байгаа А4 цаасны стандарт нь Цаасны арзгар, гөлгөрийг тодорхойлох MNS ISO 8791-2000, ус нэвтрэлтийг тодорхойлох MNS ISO 5633-2000, агаар нэвтрэлтийг тодорхойлох MNS ISO 5636-1-2000<sup>229</sup>.

Гаалийн Ерөнхий газрын мэдээгээр 2003 оноос эхлэн А4 цаасны хэрэглээ уламж өсч, жилд дунджаар 3000-4500 тн хүртэл цаас импортлогдон орж ирж байна.

### **Б. Эко парк.**

Эко парк нь аж нэгж байгууллага нь бизнесийн хүрээнд хамтран ажиллаж, бохирдол, хог хаягдлыг багасгах асуудлыг шийдэж, нөөцийг үр ашигтай ашиглах / тухайлбал, мэдээлэл, материал, ус, эрчим хүч, дэд бүтэц зэрэг багасгах зорилгоор өөр хоорондоо болон орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах аж үйлдвэр/, мөн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчны чанарыг сайжруулах зорилгоор тогтвортой хөгжилд хүрэхэд чиглэсэн үйл ажиллагаа юм<sup>230</sup>.

Ногоон эдийн засгийн мөн чухал сэдэв болох эко паркийн асуудал мөн. Монгол улсад эко парк, эко үйлдвэр, эко-инноваци болон эко-үйлдвэрлэлийн парк гэсэн эдгээр ойлголтууд нь судалгааны түвшинд явагдаж байгаагаас гадна ногоон хэрэглээ, ногоон үйлдвэрлэлийг бий болгох үндсэн ухагдахуун нь нийгэмд тархсан ойлголт болон мэдээлэл нь муу байхаас гадна хууль болон бодлогын шинэчлэлийг баталж, цаашид хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөнд санхүү, чиглэл, зорилго зэрэгт дорвитой шинэчлэл хийх нь дэлхий дахины зорилго болон Монгол улсын Ногоон хөгжлийн бодлогын үр дүнд бага хугацаанд хүрч чадах ба үүнийг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлага гарч байгаа хэрэг юм.

Монголын үлгэр жишээ болсон байгууллага, хувийн хэвшлийн компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд ногоон эдийн засгийн зарчмыг хүлээн ажиллаж буй компаниудыг дурьдвал, Тогтвортой санхүүжилтийн санаачлага /ТоС/, АПУ компанийн хүрээлэн буй орчны бодлого, М-Си-Эс Кока-кола<sup>231</sup> компаниудыг дурьдаж болно.

Эко парк гэсэн нэр томъёоны хүрээнд Монгол улсад Эко паркийн төслийг байгуулахаар МХХДБҮХолбоо төслийг 2019 онд ашиглалтанд өгөхөөр ажиллаж байгаа билээ. Энэхүү эко парк нь Нарангийн Энгэр болон Цагаан Давааны төвлөрсөн хогийн цэгт өндөр технологид суурилсан, дэлхийн жишиг бүхий хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэрлэлийн цогцолбор “ЭКО ПАРК”-ийг байгуулах<sup>232</sup> ба байгуулагдсанаар нийслэл хотод нийт 20 хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр байгуулагдах бөгөөд тус үйлдвэрээс эрчим хүч, түлш гэх мэт стратегийн өндөр ач холбогдол бүхий эцсийн бүтээгдэхүүн гарган авах<sup>233</sup>

<sup>229</sup> Тогтвортой худалдан авах үйл ажиллагаа, 2016

<sup>230</sup> Frone Simona et.al, 2015

<sup>231</sup> Нэргүй, 2015

<sup>232</sup> Эко парк, 2015

<sup>233</sup> Мөн тэнд

нь байгальд ээлтэй технологи, ногоон эдийн засгийн хөгжилд чиглэсэн ажил болж буй илрэл юм.

Роман улсын судлаач, Ногоон эдийн засагт хүрэхийн тулд эко-инновацийн паркийг хэрхэн чиглүүлэн байгуулах хүрээнд, ногоон инноваци, ногоон инновацийн парк, нөөцийн үр ашигтай зарцуулалт, ногоон үйлдвэрлэлийн парк, үйлдвэрлэлийн экосистем зэргийг тайлбарласан байна.

Ногоон хөгжил, ногоон эдийн засаг, ногоон үйлдвэрлэл гэсэн зарчмууд нь нэг утга бүхий бөгөөд, эдийн засгийн уналт болон уур амьсгалын өөрчлөлт түргэссэнэй холбоотойгоор сүүлийн жилээс эхлэн эрчимтэйгээр хөгжиж эхэлсэн нэр томъёо зарчим юм<sup>234</sup>. Ногоон эдийн засгийн тулгуур ойлголт болох нөөцийг үр ашигтайгаар зарцуулах нь эдийн засгийн тогтвортой хөгжлийн үр дүнд гарсан ойлголт мөн<sup>235</sup>. Мөн ногоон үйлдвэрлэл нь маш хурдацтайгаар салбар бүрийн бүтээгдэхүүн, үйчилгээ болон технологиудад нэвтрэн өргөжиж байгаа ба энэ нь хүрээлэн буй орчны сөрөг нөлөөлөл мөн нөөцийн ашиглалтыг хянах явдал болно<sup>236</sup>. Ногоон эдийн засаг нь нөөцийг үр ашигтай ашиглах, цэвэр технологийн хөрөнгө оруулалт, бараа бүтээгдэхүүний өөрчлөлт, түүний үйлчилгээнээс гадна, зайлшгүй шаардлагагүй зүйлийг үнэ цэнэгүй болгох нь ногоон эдийн засгийн зарчмыг хангах юм.<sup>237</sup>

Эко паркийн шалгуур үзүүлэлт нь Хог хаягдлын менежмент, эрчим хүчний үр ашигтай байдал, усны менежмент, материалын урсгал, зардал, сэргээгдэх эрчим хүчний асуудлуудыг багтаасан байна<sup>238</sup>. 2000 оноос хойш Хятад болон Энэтхэг улсуудад эко үйлдвэржилт шинээр байгуулагдаж эхэлсэн бөгөөд хувийн болон засгийн газрын хүчтэй дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна<sup>239</sup>. 2013 оны байдлаар нөөцийг үр ашигтай ашиглах эко инновацийн паркийн тоогоор дэлхийд Герман 40, Франц 19, Итали 18, Испани 15 зэрэг тэргүүлэгч орнуудын эгнээнд багтаж байна /Зөвхөн Европын Холбооны улс/.<sup>240</sup>

Түүнчлэн, эко-инновацийн паркийг үндсэн 3 категориудад хуваан, ажиглалт хийгдсэнээс гадна энэ нь улсын, бүс нутгийн, нийтийн болон хувийн хэвшлийн гэсэн уялдаатайгаар холбогдсон байна.<sup>241</sup>

### ***В. Ногоон эдийн засагт халтай барилга, байгууламж***

Ногоон барилга, байгууламж нь ногоон эдийн засагт хүрэх үндсэн секторын нэг болох бөгөөд ногоон барилга, байгууламжийн тухай ойлголтыг тодорхойлсон байдаг.

<sup>234</sup> Frone Simona et.al, 2015

<sup>235</sup> Мөн тэнд

<sup>236</sup> Мөн тэнд

<sup>237</sup> Мөн тэнд

<sup>238</sup> Мөн тэнд

<sup>239</sup> Мөн тэнд

<sup>240</sup> Мөн тэнд

<sup>241</sup> Мөн тэнд

Ногоон барилга гэдэг нь барилгын ажлыг төлөвлөх, зураг төсөл зохиох, барилга барих, ашиглах, засвар хийх, барилгын насжилтын бүхий л үе шатанд хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй байх, нөөц баялгийг үр ашигтай зарцуулах, ашиглах зарчмыг хэрэгжүүлэх үйл явц юм.<sup>242</sup>

Ногоон барилгын үзэл баримтлал нь дэлхийн дулаарал, хүн төрөлхтөний анхаарлыг татаж эхэлсэн үетэй цаг хугацааны хувьд шууд холбогддог гэж үздэг.<sup>243</sup>

Дэлхийн жишигт нийцсэн ногоон барилга, байгууламжийг Япон, Америк улсууд маш сайн хэрэгжүүлж байгаагийн тод жишээ нь лийд гэрэл юм.

Монгол улс санаачлан, хууль эрхзүйн хүрээнд, “Ногоон барилга” дулааны алдагдал хамгийн бага байх хийцтэй, халаалтын шийдэл нь агаарт ялгаруулах бохирдол багатай, эрчим хүчний хэмнэлттэй, хур тунадасны усыг хуримтлуулж ашиглах, хаягдал бохир усаа цэвэрлэж зайлуулах технологи бүхий барилга, байгууламж гэж тодорхойлсон байна.<sup>244</sup> Ногоон эдийн засгийн түншлэлийн хүрээнд, ногоон барилгыг Монгол улсад хөгжүүлэх зорилго тавьж, барилгын ногоон зураг төсөл боловсруулах, барилгын нийгэм, эдийн засаг, байгаль орчны үнэлгээ, шинжилгээг хийх, барилга байгууламжийг ногоон болгох стратегийг боловсруулах ажил хийгдэж эхэлсэн болно.<sup>245</sup>

Дээрх тодорхойлолт болон бодлогын хүрээнд, ногоон барилга, байгууламжийг ашиглах түүнийг зарчмын хүрээнд дэмжих зэрэг ажлууд нь одоогоор ахицтай түвшинд агрч ирж байгаа.

Энэхүү асуудлын хүрээнд, Филиппин улсын Ногоон эдийн засаг болон барилга байгууламжийн байгаль орчинд халтай барилгыг танилцуулж түүнд дүн шинжилгээ хийсэн байна. Энэхүү судалгаанд мэдээ материал, баримт бичиг, санал асуулганд тулгуурлан, 2010 оноос 2012 оны хооронд судалгаа хийгдэж нийт 53 секторын ажилчдаас ярилцлагын аргаар судалгаа авсан бөгөөд, үүнд, хөдөө аж үйлдвэрлэл болох /биомасс, биотүлш, каучкан бүтээгдэхүүн/, уулархаг газрын барилга, байгууламжийн хүрээлэн буй орчин болон ард иргэд /үүнд: тэдний үзэл бодол, хур тунадас, итгэл найдвар, сүсэг бишрэл/ болон өндөр газрын хөгжлийн талаарх асуудлуудыг тусгасан болно. Үүний үр дүнд, өндөрлөг газарт байрлаж буй улс орнуудын ногоон эдийн засгийн хөгжил нь удаашралтай мөн хүндрэлтэй асуудлууд болохоос гадна, бодлого гаргагчийн түвшинд хүндрэлтэй асуудлууд тулгарч байна. Газар тариалан, хөдөө аж ахуйн газрын ашиглалт зэрэг нь уулархаг газарт жил ирэх тусам бүтээмж буурч, цаашид ашиглах боломжгүй болж буй нь тулгамдаж буй асуудлууд болж байгаа юм.

Үүнд колончлолын болон орчин үеийн ард иргэдийн газар ашиглалтын төлөв байдал нь ялгаатай байсан.<sup>246</sup> Колончлолын үед, хэрэгцээгүй болсон бэлчээр, хадлангийн газар болон атаржсан газар тариалангийн талбайд эдийн

<sup>242</sup> Нэргүй, 2015

<sup>243</sup> Мөн тэнд

<sup>244</sup> Мөн тэнд

<sup>245</sup> Сургуулийн ногоон барилга, 2015

<sup>246</sup> Marvin Joseph F et.al, 2016

засгийн хөгжлийн хүрээнд тухайн газрын нөхөн сэргээлт хийж барилгажуулдаг байсан харин ногоон эдийн засаг нь хүрээлэн буй орчны нөхөн сэргээлт хийх, нүүрсхүчлийн хийг бууруулах нь дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн багасгаж байгааг баталж байна.<sup>247</sup>

Тогтвортой барилга байгууламжийн дизайны шийдэл нь дэлхийн улсуудад судлагдаж, түүний шаардлагыг хангасан шалгуур үзүүлэлт зэргүүдийг боловсруулсан байна. Ногоон барилга гол нөлөөлөл нь тухайн гол зам нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгасан байх шаардлагыг харгалздаг байна.<sup>248</sup> Мөн, дэлхийн хэмжээнд ногоон барилгажилтыг зэрэглэл тогтоон эрэмбэлэн кредит ноогдуулах систем нэвтэрч энэ нь маш үр дүнтэй арга хэрэгсэл болж байна. Ихэнх дэлхийн улсууд энэхүү ногоон барилга байгууламжийн зэрэглэл тогтоох системийг хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээрт, АНУ, Канад, Австрали, Хонг-Конг Япон, Тайван, Сингапур, Филиппин, Европын Холбооны улсууд, Солонгос, Энэтхэг болон Австари кэрэг амжилттайгаар хэрэгжүүлж байна.<sup>249</sup> Үүнээс улбаалаад, замын тогтвортой байдлыг эрэмбэлэх шалгуур үзүүлэлт гарч ирснээс шалтгаалан 3-н шалгуурыг тогтоосон болно, эдгээрт *Ногоон зам, Шилдэг технологи бүхий Ногоон тээврийн хэрэгсэл, Таатай нөхцөл бүхий тогтвортой тээврийн хэрэгсэл* багтана.<sup>250</sup>

Малайзын ногоон байгууламж болон замыг шалгуур үзүүлэлтүүдийг хүчин зүйлийн анализаар судлан, тогтвортой дизайн, тогтвортой барилга байгууламж гэсэн үндсэн 2 катергорт хуваан шалгуур үзүүлэлтүүдийг тусган мөн түүний дэд шалгуур үзүүлэлтүүд гэсэн хэсгээс бүрдсэн дүн шинжилгээ хийсэн байхаас гадна, Жишээлбэл, агаарын бохирдолтыг хянах гэсэн үндсэн шалгуур нь дотроо хүлэмжийн хийн ялгаралын бууралт, тоосны тархалтыг хянах зэрэг дэд шалгуур үзүүлэлт зэргийг тусгасан байна.<sup>251</sup> Үүний үр дүнд, шалгуур үзүүлэлт нь ногоон барилга, түүний дизайн болон замын тогтвортой байдалтай харилцан холбоотой бөгөөд, дээрх шалгуур үзүүлэлтүүдийг шинжлэх ухааны түвшинд нарийн загвар, тооцоолол хийх ач холбогдолтой юм

### ***Г. Ногоон ажлын байр.***

НҮБ-ийн Байгаль орчны холбооны тодорхойлсоноор байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбар, шинжлэх ухаан, засаг захиргааны болон үйлчилгээний чанартай ажил хөдөлмөр эрхлэлтийг ногоон ажлын байр гэнэ.<sup>252</sup>

Олон улсын хөдөлмөрийн байгууллаг нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар байгаль орчин, эдийн засаг, нийгмийн талаас авч

<sup>247</sup> Marvin Joseph F et.al, 2016

<sup>248</sup> Raja Rafidah Raja Muhammad Rooshidi et.al, 2014

<sup>249</sup> Мөн тэнд

<sup>250</sup> Мөн тэнд

<sup>251</sup> Мөн тэнд

<sup>252</sup> Нэргүй, 2015

үзэхэд тогтвортой аж ахуй, эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд тус нэмэр болж буй ажлын байрыг ногоон ажлын байр гэнэ.

Ногоон ажлын байрыг тодорхойлохдоо, ногоон хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд хэрхэн нийцэж буй эсэхээс шалтгаалан ногоон ажлын байрыг эрэмбэлэн тогтоодог. Ажлын байрны хүрээнд ногоон байгууламж, цэцэгжүүлэх гэхээс өргөн цар хүрээтэйгээр байгаль орчинд ээлтэй байх технологи, хэрэглэг өөрсдийн дадал зуршил болгон хэрэгжүүлж байгаа эсэхээс шалтгаалан, ногоон ажлын байрыг тодотгон дүгнэнэ.

Мөн, ногоон ажлын байрны судалгааны цар хүрээ нь ажилгүйдэл, ажил хөдөлмөр эрхлэлт зэргээс хамааралтайгаар ногоон гэх тодотголыг гаргаж ирж ойлгох явдал юм.

Ихэнх нийтлэлд, одоогийн ажлын эрхлэлт нь өнгөрсөн буюу ирээдүйд хэх хэмжээний бохирдол, сөрөг нөлөөлөл учруулж буйгаар эрэмбэлэн тодорхойлдог байна. Үүнээс гадна, Европын холбооны улсуудын хөдөлмөр эрхлэлтийн нөлөө нь нүүрс хүчлийн хийн ялгаралтыг бууруулахад нөлөөлж буй эсэхийг анализ, дүн шинжилгээ хийсэн судалгааны арга зүй, үр дүнгээс харахад, ажилгүй, ажил эрхэлдэг хүмүүс хоорондын хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн шинжилгээг нарийвчлан тодорхойлон, мөн салбар бүрийн ногоон ажлын байрын үндсэн үзүүлэлт зэргийг тодорхойлж, эко оффис, эко ажлын байрны эрэмб, нөлөөллийг тогтоосон байна.<sup>253</sup>

Монгол улсын хэмжээнд ногоон ажлын байрны тодорхойлолтонд дүйцэхүйц, ногоон эдийн засгийг дэмжин ажиллаж буй хувийн болон улсын хэвшлийн албан байгууллагууд идэвхтэй оролцож байгаа болон импортлогч бараа, бүтээгдэхүүнүүд эдийн засагтай хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй байх техник, технологийг нэвтрүүлэн олон нийтэд түгээн дэлгэрүүлж байгаа нь ард иргэдийн байгаль орчноо хамгаалах, цаашлаад хувийн эдийн засагт ашигтай байх тэрхүү эдийн засгийг дэмжин, хамтарч байгаа нь сайшаалтай билээ.

Үүний нэг жишээ болох Голомт банк нь анхны цаасгүй хэрэглээтэй банк хэмээн зарласны үр дүнд цахим хэлбэрт шилжин ажиллаж байгаа билээ.

---

<sup>253</sup> Anil Markandya et.al, 2016



## ДҮГНЭЛТ

Дэлхийн байгаль хамгаалах холбооноос хэд хэдэн төслүүдийг хэрэгжүүлэн амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү төслийн чиг хүрээнд Ногоон эдийн засгийн түншлэл, ногоон эдийн засгийн орчинг улс орон бүр дэвшүүлж хамтран ажиллах ба Ази тивийн улсуудын дунд Монгол улс анхдагч орнуудын тоонд хамрагдаж байгаа нь энэхүү Ногоон эдийн засгийн өргөжүүлэн хөгжүүлэхэд давуу тал болж байгаа юм.

Ногоон эдийн засгийн ойлголтыг экологийн боловсролын цар хүрээтэй адилтган авч үзэж, иргэн бүрийн ногоон эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарах төсөлт ажил явуулах, их, дээд сургуулиудын эзэмшиж буй мэргэжлийн чиглэлийн хичээлийн хөтөлбөр бүрт ногоон эдийн засгийн ойлголтыг тусгаж түүнд шаардлагатай боловсон хүчнийг бэлдэх, санхүүгийн асуудлыг бүрэн улсаас дэмжин шийдвэрлэх зэрэг арга хэрэгслүүд багтана.

Дэлхийн улс орон бүрийн ногоон эдийн засгийг амжилттай хэрэгжүүлж, бүрэн хэрэглэж буй улс орон бүр төсөл, хөтөлбөрийг дэс дараатайгаар хэрэгжүүлэн зөвхөн гадны сан, тэтгэлэгээс илүүтэйгээр засгийн газар тодорхой хэмжээний шаардлагатай хөрөнгөөр санхүүжүүлэн, ногоон түншлэлийн цар хүрээг өргөн тэлсэн туршлага харагдаж байна, үүнээс гадна, ногоон эдийн засгийн хүрээнд хэрэгжиж болох судалгаа, шинжилгээний ажлуудыг шинжлэх ухааны үндэслэл бүхий, дэвшилтэт аргазүй, аргачлалыг ашиглах явдал нь энэхүү ногоон хөгжлийн ирээдүйн болон одоогийн тулгамдаж буй асуудлуудыг шийдэхэд хамгийн тохиромжтой арга болж байна.

**НОМ ЗҮЙ**

1. “Ногоон эдийн засгийн үндэс”, Д.Нэргүй, БОНХАЖЯ, PAGE төслийн хүрээнд, 2015 он
2. United Nations Environment Program (UNEP). *What is green economy*. Retrieved from: <http://www.unep.org/greeneconomy/AboutGEI/WhatisGEI/tabid/29784/Default.asp>
3. “Ногоон хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх үндэсний тэргүүлэх чиглэл” Илтгэл, БОНХАЖЯ, Сангийн яам, 2016 он
4. “Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл” PAGE төсөл, гарын авлага, 2016 он
5. “Тогтвортой худалдан авах ажиллагаа” Сангийн яам, PAGE төсөл, Илтгэл, 2016
6. “Монгол улсын А4 цаасны өнөөгийн хэрэглээний болон зах зээлийн зарим судалгааны үр дүнгээс” Илтгэл, Ц.Даваахүү, 2016 он
7. “Forests in a Green Economy: A Synthesis” by UNEP, Green Economy briefly paper, Job number DTI/1406/GE, 2013. Retrieved from: <http://www.unep.org/greeneconomy/GE Briefing papers/tabid/1406/Default>
8. United Nations Environment Program (UNEP). *What is green economy*. “Green procurement Briefing Paper”, 2009. Retrieved from: <http://www.twosidesna.org/download/FPAC-Green-Procurement-Briefing-Paper.pdf>
9. <https://engineering.dartmouth.edu/~d30345d/courses/engs171/Paper.pdf>
10. “Эко парк” төсөл, МХХДБҮХолбоонд дээр хэрэгжиж буй төслийн товч танилцуулга, 2015 он
11. [https://en.wikipedia.org/wiki/Eco-industrial\\_park](https://en.wikipedia.org/wiki/Eco-industrial_park)
12. Frone Simona, Senior researcher Ph.D, The Eco-Innovation Parks: Vectors Transition to a Green Economy. Economy Series, Special ECO-Trend 2015-Performance, Competitiveness, Creativity, ISSN 2344-3685/ISSN-L 1844-7007, 2015
13. Marvin Joseph F. Montefrio, Wolfram H.Dressler. (2016). “Green Economy and Constructions of the ‘IDLE’ and ‘UNPRODUCTIVE’ Uplands in the Philippines, *World Development* Vol.79, pp. 114-126, 2016
14. “Сургуулийн ногоон барилга гарын авлага” БОНХАЖЯ, PAGE Төслийн хүрээнд, 2015
15. Raja Rafidah Raja Muhammad Rooshdi, Nurizan Ab Rahman, Nazurah Zahidah Umar Baki, Muhd Zaimi Abdul Majid, Faridah Ismail. (2015). “An evaluation of sustainable design and construction criteria for green highway. *Procedia Environmental Sciences* 20 (2014) 180-186
16. Anil Markandya, Inaki Arto, Mikel Gonzalez-Eguino, Maria V. Roman. (2016). “Towards a green energy economy? Tracking employment effects of low-carbon technologies in the European Union. *Apply Energy* (2016), 036-2619